



МОНГОЛ УЛС  
ХӨВСГӨЛ АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН  
ЗАХИРАМЖ

2024 оны 03 сарын 13 өдөр

Дугаар А/113

Мөрөн сум

Ажлын гүйцэтгэлийн төсвөөс  
санхүүжүүлэх тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 60 дугаар зүйлийн 60.1.1, 60.1.2, 60.1.5, 66 дугаар зүйлийн 66.1, Төсвийн тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.2.3, 41 дүгээр зүйлийн 41.2.6, 65 дугаар зүйлийн 65.1.4, аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2023 оны 12 дугаар сарын 01-ний өдрийн ээлжит XXIII хуралдааны 04 дүгээр тогтоолыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Улсын төсвийн хөрөнгө оруулалтаар Бүрэнтогтох, Их-Уул, Эрдэнэбулган, Рашаант, Мөрөн сумдад инженерийн хийцтэй гүн өрмийн худаг барих ажлын зураг төсөл боловсруулах “Ажлын гүйцэтгэл”-ийн төсвөөс санхүүжүүлэх зөвлөх үйлчилгээний төлбөрийн төсөвт өртгийн дээд хязгаарыг хавсралтаар баталсугай.


2. Төсөл арга хэмжээний зураг, төсвийг боловсруулах зөвлөх үйлчилгээ нийлүүлэх гүйцэтгэгч сонгож гэрээ байгуулах, хэрэгжилтийг хангах үйл ажиллагааг зохион байгуулж ажиллахыг аймгийн Засаг даргын Тамгын газрын Хөгжлийн бодлого, төлөвлөлт, хөрөнгө оруулалтын хэлтэс (Б.Оюунтуяа), Хүнс, хөдөө аж ахуйн газар (Я.Эрхэмбаяр), сумдын Засаг дарга, нарт тус тус үүрэг болгосугай.

3. Төсөл арга хэмжээнүүдийн зураг төсвийн үнийг хавсралтад заагдсан эх үүсвэрээс санхүүжүүлэхийг аймгийн Засаг даргын Тамгын газрын Санхүү, төрийн сангийн хэлтэс (Г.Базар), Хөгжлийн бодлого, төлөвлөлт, хөрөнгө оруулалтын хэлтэс (Б.Оюунтуяа) нарт тус тус даалгасугай.

4. Захирамжийн хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг аймгийн Засаг даргын Тамгын газар (Э.Улам-Өсөх)-т даалгасугай.

ДАРГА

П.ЛХАГВАЖАВ





Аймгийн Засаг даргын 2024 оны 03 дугаар  
сарын 13-ний өдрийн А/113 дугаар  
захирамжийн хавсралт

УЛС, ОРОН НУТГИЙН ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТААР ШИНЭЭР БАРИХ, ЗАСВАРЛАХ,  
ШИНЭЧЛЭХ БАРИЛГА БАЙГУУЛАМЖИЙН "АЖЛЫН ГҮЙЦЭТГЭЛ"-ИЙН ТӨСВӨӨС  
САНХҮҮЖҮҮЛЭХ ЗУРАГ ТӨСӨЛ БОЛОВСРУУЛАХ ЗӨВЛӨХ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ  
ТӨСӨВТ ӨРТГИЙН ДЭЭД ХЯЗГААР

№	Арга хэмжээний нэр	Төсөвт өртөг	тайлбар
1	Бүрэнтогтох сумын Туяа багийн Бор хөндий, Их-Уул сумын Мандал багийн Бага-Ацын Алаг толгой, Эрдэнэбулган сумын Удган багийн Баянголын Бэрхийн ам, Рашаант сумын 5, 2 дугаар багийн зааг, Баянголын хөндий Шар жалга орчим, Мөрөн сумын 9 дүгээр багийн Устын аманд инженерийн хийцтэй гүн өрмийн худаг барих ажлын зураг төсөл боловсруулах	6,000,000	Холбогдох хууль тогтоомж, барилга байгууламжийн норм, нормативын баримт бичигт заасан шаардлагыг хангасан байна
	Нийт дүн	6,000,000	

\_\_\_оОо\_\_\_